



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар Д/121

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.6 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Дадал сумын цэцэрлэгийн барилгыг өргөтгөсөнтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заасан “7” бүлэг байсныг “8”, барилгын хүчин чадал “125” байсныг “200” болгон өөрчлөлт оруулсугай.

2.Өөрчлөлтийн талаарх мэдээллийг тус цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тэмдэглэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ